

МУИС-ийн Завхан сургуулийн нэрэмжит XI олимпиадын тест
Нийгмийн тухай мэдлэг /2017/

Шифр.....

Хугацаа 80 минут

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.

2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой. Зөв хариулт бүр 1 оноотой

1. Нийгмийн давхраажилтын шатаар хүмүүс дээш, доош юм уу хэвтээ чиглэлээр шилжих үйл явцыг хэрхэн тодорхойлдог вэ? (1оноо)
А. Нийгмийн ялгарал В. Нийгмийн хөдөлмөрийн хуваарь Д. Хүн амын шилжилт
С. Нийгмийн шилжих (мобиль) хөдөлгөөн Е. Хүн амын нягтшил
2. Нийгмийн хамгаалал хэнд чиглэгдэж байх ёстой вэ? (1оноо)
А. Эмзэг хэсгийнхэнд В. Ажилгүйчүүдэд С. Нийгмийн элит хэсгийнхэнд
D. Нийгмийн бүх гишүүдэд E. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд
3. Нийгмийн даатгалын төрөлд үл хамаарагдах зүйл аль нь вэ? (1оноо)
А. Ажилгүйдлийн В. Тэтгэврийн С. Үйлдвэрийн ослын D. Хөрөнгийн E. Эрүүл мэнд
4. Хязгаар нутгуудаас шилжин ирэгсдийн тоог хязгаарлах замаар Засгийн газар ажилгүйдэлтэй тэмцэж байгаа бол энэ нь ажилгүйдлийг бууруулах ямар арга замыг хэрэглэж байна вэ? (1оноо)
А Эдийн засгийн арга В. Гадаад хүчин зүйлийг ашиглах арга
С. Улс төрийн арга D. Захиргааны арга E. А ба С хариулт
5. Зах зээлийн механизмд “өршөөл” гэж байхгүй. Энд ихээхэн өмч хөрөнгө, капитал, газар эсвэл оюуны боловсрол өндөртэй хүмүүс их ашиг хүртэж, бусдад нь бага хувь оногдох магадлалтай. Мөн нийгэмд эмзэг бүлгийнхэн оршоор байдаг. Энэ тохиолдолд төр эдийн засагт ямар зохицуулалт хийх ёстой вэ? (1оноо)
А. Эрх зүйн үндсийг бүрдүүлэх В. Өрсөлдөөнийг хамгаалах С. Орлогыг дахин хуваарилах
D. Эдийн засгийг тогтворжуулах E. Эдийн засгийг хямралаас гаргах
6. Хэрвээ иргэн Дорж хангалттай хөрөнгөтэй, гадаад хэл, компьютерийн өргөн мэдлэгтэйгээр өөрийн бизнесийг эхэлсэн боловч алдагдалд орсон бол энэ нь ямар хүчин зүйлийн дутагдлаас болсон бэ? (1оноо)
А.Капитал В.Газар С.Бизнесийн хамтрагч
D. Төрийн дэмжлэг C.Үйлдвэрлэл эрхлэх чадвар
7. гэдэг бол нийгэмд гүйцэтгэх үүргийг нь төрөөс хуулиар тогтоож өгсөн байдаг нийгмийн бүлгүүд юм. (1оноо)
А. Боолчлол В. Анги С. Каст D. Ялгарал E. Язгуур
8. Америкийн нийгэмд “хөх цамцангууд” гэж ямар ангийг нэрлэдэг вэ? (1 оноо)
А. Дээд анги В. Дунд анги С. Ажилчин анги D. Доод анги E. Хотод оршин суугчид
9. Социализмийн үеийн Монголын анги давхарааны бүтцийн зөв загварыг олно уу. (1оноо)
А. Ажилчин, малчин, сэхээтэн В. Тариачин, албан хаагч, ажилчин
С. Дарга, ажилчин, малчин D. Албан хаагч, үйлдвэрлэгч, худалдагч E. Дээд анги, дунд анги, доод анги
10. Ангийн чинь нэг сурагч чамд хоч өгөх нь ямар дургүйцэл санкц вэ? (1 оноо)
А. Албан ёсны В. Албан ёсны бус С. А, В хоёулаа
D. Хоч авагч өөрөө буруутай тул асуулт оновчгүй E. Эдгээрээс өөр
11. Нийгмийг зөвхөн нийгмийн хүчин зүйлээр тайлбарлах бөгөөд нийгмийн үйл явцад байгалийн хүчин зүйлс бараг үүрэггүй гэж үздэг онол байдаг. Энэ онолын төлөөлөгчдөөс В.Парето, Г.Моска нар доорх өгөгдлийн аль үзлийг баримтлагчид вэ? (1 оноо)
А. Сэтгэл зүйн сургаалтнууд В. Элитийн онол С. Эдийн засгийн онолтууд
D. Бүтэц, үүргийн онол E. Иргэншлийн онол
12. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол “... гэдэг нь нийгэм ба соёлоос хожуу үүссэн ч дэлхийчлэлийн цар хүрээний ач холбогдолтой, нийгэм ба нийгэмлэгүүдийн соёлын хөгжлийн шат түвшин болон тэдгээрийн өвөрмөц шинжийг тусгасан ойлголт” юм. (1 оноо)
А. Даяаршил В. Нийгэмшил С. Иргэншил D. Уламжлал E. Эдгээрээс өөр
13. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нэг үеэс дараагийн үед тухайн нийгэмд дээдлэгдэгч соёлыг уламжлуулан залгамжлуулах хойч үеийг бэлтгэх чиг үүрэгтэй. (1 оноо)
А. Улс төр В. Шашин С. Боловсрол D. Гэр бүл E. Эдийн засаг
14. Нийгмийн тогтолцоот чанарын талаас үүргийн хандлагын үндсэн ойлголтыг хэн анх “Социологийн үндэслэл” хэмээх бүтээлдээ боловсруулсан бэ? (1 оноо)
А. Г.Спенсер В. Р.Мертон С. Т.Парсонс D. К.Маркс E. Эдгээрээс өөр
15. Хөгжлийн явцад хүмүүс хоорондоо хүссэн хүсээгүй ялгаралд орж байдаг. Жижиг бүлэгт бие бялдраараа ялгарч байдаг бол, томоохон орчинд ялгардаг гэж Г.Зиммель үзжээ. (1 оноо)
А. Эд баялгаар В. Эрх мэдлээр С.Оюун ухаанаар D. Боловсролоор E. Бусад зүйлээр
16. Эзэлж буй статусаас хамаарч нийгмийн хүлээлтээр тодорхойлогдсон зан үйлийн хэмжээнүүдийн цогцыг юу гэдэг вэ? (1оноо)

- A. Нийгмийн хүлээлт В. Нийгмийн үүрэг С. Нийгмийн үйлдэл
D. Нийгмийн функц Е. Эдгээрээс өөр
17. Нийгмийн өсөн нэмэгдэж буй ээдрээтэй байдлын шалтгаан, үр дагавар юм. (1 оноо)
A. Нийгмийн өөрчлөлт В. Нийгмийн хувьсал С. Хөдөлмөрийн хуваарь
D. Нийгмийн дэвшил Е. Эдгээрээс өөр
18. Нэгдэл холбоо нь өөрийн өмч болох нутаг дэвсгэртэй, уг нутаг дэвсгэр нь өөрийн нэр өөрийн түүхтэй гэж хэн хэлсэн бэ? (1 оноо)
A. Э. Шилз В. Р. Мертон С. Платон D. Р. Марш Е. Аристотель
19. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. ... институт нь нийгмийн хүн амын нөхөн үйлдвэрлэлийг хангаж хойч үеийг өсгөн хүмүүжүүлэх функцыг хэрэгжүүлдэг. (1 оноо)
A. Улс төр В. Эдийн засаг С. Боловсрол D. Гэр бүл Е. Хамт олон
20. Цэгийн оронд тохирох үгийг өгөгдлөөс ол. Хувь хүмүүсийн хоорондын өдөр тутмын харилцааны явцад статусаас нь хамааран тодорхой, тогтвортой холбоо тогтох нь ... юм. (1 оноо)
A. Нийгмийн харилцаа В. Нийгэм хоорондын харилцаа
C. Институт хоорондын харилцаа D. Байгууллага, бүлэг, нийтлэл хоорондын харилцаа
E. Эдгээрээс өөр
21. Нийгмийн тогтвортой байдал нэгдлийг дэмжин тэтгэгч 3 гол институт байдаг ажээ. Илүүцийг ол. (1 оноо)
A. Гэр бүл В. Төр засаг С. Шашин D. Боловсрол Е. Эдгээрээс өөр
22. Үйлдвэрт шинэ техник технологи нэвтрүүлэхэд үүсэх ажилгүйдэл аль нь вэ? (1 оноо)
A. Мөчлөгийн ажилгүйдэл В. Үйлдвэрийн ажилгүйдэл С. Бүтцийн ажилгүйдэл
D. Завсрын ажилгүйдэл Е. Хүлээлтийн ажилгүйдэл
23. Бараа үйлчилгээний нийт хэмжээг түүний үнээр үржүүлж, мөнгөний эргэлтийн тоонд харьцуулсан нь эдийн засгийн ямар үзүүлэлтийг тодорхойлох вэ? (1 оноо)
A. Хэрэглээний барааны үнийн индекс В. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо
C. Тэнцвэрт үнэ D. Банкинд байгаа мөнгөний дүн Е. Зах зээлийн үнэ
24. Хөдөлмөрийн зах зээл дээр дээд боловсролтой мэргэжилтнүүд олноор бэлтгэгдэж гарч байгаа ч мэргэжлээрээ ажиллахгүй байгаагийн шалтгаан юу вэ? (1 оноо)
A. Хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт эрэлтээсээ давж илүүдэл үүссэн
B. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтээсээ давж илүүдэл үүссэн
C. Хөдөлмөрийн зах зээл дээрх нийлүүлэлт эрэлтээсээ давж хомсдол үүссэн
D. Хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтээсээ давж хомсдол үүссэн
E. Зөв хариулт алга байна.
25. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санаачлагыг ямар байгууллага, албан тушаалтан гаргах вэ? (1 оноо)
A. Үндсэн хуулийн цэц В. Үндсэн хуулийн цэцийн дарга
C. УИХ-ын гишүүн D. Улсын дээд шүүх Е. Шүүхийн ерөнхий зөвлөл
26. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналыг УИХ-д хэн өргөн мэдүүлэх вэ? (1 оноо)
A. Үндсэн хуулийн цэц В. Ерөнхийлөгч С. Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөн
D. УИХ-ын дарга Е. Эрх барьж буй улс төрийн намын дарга
27. Төрөөс авч явуулсан эдийн засгийн арга хэмжээ, түүний зорилгын зөв харгалзуулна уу (3 оноо)

1. Байгууллагуудын төсөвт төлөх ёстой нэмэгдэх
 2. Төсөвт байгууллагын ажилчдын
 3. Байгууллагын хариуцан төлдөг нийгмийн
- A. Далд эдийн засаг ил гарах, бизнес татварын өрийг хүчингүй болгохоор эрхлэгчдийн ачааллыг хөнгөлөх, техник “Татварын өршөөлийн хууль” батлах технологийн шинэчлэлт хийх, хөрөнгө оруулалт
- B. Ажилчдын цалин нэмэгдэх бодит боломж цалинг нэмэх нээгдэх
- C. Хүмүүсийн худалдан авах чадвар дээшилж даатгалын шимтгэлийг 19 хувиас 11 хувь өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх болгож бууруулах
- A. 1A 2B 3C B. 1A 2C 3B C. 1B 2A 3C D. 1B 2C 3A E. 1C 2A 3B
28. Монгол улс дахь шатахуун импортлодог компаниуд шатахууны үнийг нэмэхээр тохиролцож буй нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ? (1 оноо)
- A. Төгс өрсөлдөөнт B. Олигополь C. Монопольт өрсөлдөөнт
- D. Өрсөлдөөнт бус E. Монополь
29. Монгол улс 1992 онд ямар инфляцийг даван туулсан бэ? (1 оноо)
- A. Далд инфляци B. Хэт инфляци C. Цогио инфляци
- D. Хэвийн инфляци E. Мөлхөө инфляци
30. Соёлыг судалдаг шинжлэх ухааны салбаруудыг нэрлэхдээ илүү зүйл дурьдсан бол аль нь вэ? (1 оноо)
- A. Философи B. Хүн судлал C. Социологи D. Улс төр судлал E. Угсаатны зүй
31. Соёлын хэлбэрүүдийг онцлогтой нь зөв харгалзуулна уу. (4 оноо)
1. Элитийн соёл A. Бүх насныхан, бүх давхаргад хүртээмжтэй
 2. Ардын соёл B. Энэ соёлын хэрэглэгчид нь нийгмийн өндөр боловсролтой хэсэг
 3. Нийтийн соёл C. Нийгмийн бүлгүүд өөрийн үнэлэмж, зан байдлын дүрмүүд, соёлыг бүтээдэг
 4. Дагуул соёл D. Энэ соёлыг ардын билиг авъяастнууд бүтээдэг
- A. 1B 2D 3A 4C B. 1D 2C 3A 4B C. 1C 2A 3D 4B D. 1C 2D 3B 4A E. 1D 2B 3A 4C
32. Алдагдсан боломжийн өртөгтэй шууд холбоотой ойлголт аль нь вэ? (2 оноо)
- A. Үйлдвэрлэлт B. Борлуулалт C. Сонголт D. Төрийн зохицуулалт E. Худалдан авалт
33. Та бараа, үйлчилгээ худалдан авахдаа төлсөн нэмэгдсэн өртгийн татвар нь (2 оноо)
- A. Төлбөр B. Шууд бус татвар C. Хураамж D. Шууд татвар E. Шимтгэл
34. Эдийн засгийн хямралын үед үүсэх ажилгүйдэл (2 оноо)
- A. Мөчлөгийн ажилгүйдэл B. Үйлдвэрийн ажилгүйдэл C. Бүтцийн ажилгүйдэл
- D. Завсрын ажилгүйдэл E. Хүлээлтийн ажилгүйдэл
35. Төрийн өмчийг хувьд шилжүүлэх арга (2 оноо)
- A. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах B. Дуудлагаар худалдах
- C. Үнэ төлбөргүй шилжүүлэх D. Дээрх бүгд зөв E. А ба В
36. Тухайн улсын зөвхөн нэг жилд үйлдвэрлэн бий болгосон материал баялгийн хэмжээг гэнэ.(2 оноо)
- A. Дотоодын нийт бүтээгдэхүүн B. Үндэсний цэвэр бүтээгдэхүүн C. Үндэсний орлого
- D. Үндэсний нийт бүтээгдэхүүн E. Дотоодын цэвэр бүтээгдэхүүн
37. Ажилгүйдлийн түвшин гэдэг нь (2 оноо)
- A. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхэлж байгааг илэрхийлнэ
- B. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
- C. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
- D. Хөдөлмөрийн чадвартай хүн амын хэдэн хувь нь ажил эрхлэхгүй байгааг илэрхийлнэ
- E. Нийт хүн амын хэдэн хувь нь ажил хайж хөдөлмөрийн биржид бүртгэлтэй байгааг илэрхийлнэ
38. Бага зардлаар бүтээгдэхүүн үйлдвэрлэж, түүнийгээ хурдан хугацаанд борлуулж чадсан нь ашиг олж, цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болно. Ингэж чадаагүй нь дампуурч зах зээлээс гарах хууль үйлчилнэ. Үүнийг шалгарлын хууль гэх ба эдийн засгийн ямар ойлголтоор дамжин хэрэгжих вэ? (2 оноо)
- A. Эрэлт, нийлүүлэлт B. Ажилгүйдэл C. Үл үзэгдэгч гар D. Өрсөлдөөн E. Инфляци
39. “Төр бол хамгийн муу менежер” гэсэн нь ямар утгыг илэрхийлж байгаа вэ? (2 оноо)
- A. Төр нь эдийн засгийн амьдралд гүйцэтгэх үүргээ биелүүлдэггүй
- B. Эдийн засгийн амьдралд төрийн оролцоо шаардлагагүй
- C. Төр бол менежер биш
- D. Төрийн оролцоотой бизнесийн үйл ажиллагаа төдийлөн амжилттай байдаггүй
- E. Дээрх тодорхойлолтууд бүгд буруу
40. 2008 оны эхээр Монголбанк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь төрийн зүгээс эдийн засгийг тогтворжуулахаар хэрэглэсэн ямар арга хэмжээ вэ? (2оноо)
- A. Ажилгүйдлийг бууруулах B. Орлого дахин хуваарилах C. Инфляцийг барих
- D. Ядуурлыг бууруулах E. Төсвийн алдагдлыг багасгах
41. Монгол улсын гар утасны зах зээл дээрх өрсөлдөөнийг . . . зах зээл гэнэ. (1оноо)
- A. Төгс өрсөлдөөнт B. Олигополь C. Монопольт өрсөлдөөнт

- D. Өрсөлдөөнт бус E. Монополь
42. “Demokratos” гэсэн үг утга гарлын хувьд доорх өгөгдлүүдээс алинд нь тохирч байна вэ? (1 оноо)
 A. “Ардчилал”, грек үг B. “Шууд ардчилал”, англи үг C. “Ард түмэн”, грек үг
 D. “Засаг”, латин үг E. “Төр улс”, франц үг
43. Улс төрийн системийн эргэх холбоо нь нийгэмд ямар үүрэг гүйцэтгэхийг доорх өгөгдлөөс олно уу? (1 оноо)
 A. Нийгэмд түгшүүрт байдал бий болохоос урьдчилан сэргийлэх гол механизм
 B. Мэдээлэл хүлээн авах гол механизм C. Мэдээллийг нийгэмд хүргэх гол механизм
 D. Нийгмийг шинэчлэх зорилготой механизм E. Эдгээрээс өөр
44. Орчин үед фашизм, нацизм, Сталины коммунизмыг доорх ангиллын алинд нь сонгодог жишээ болгодог вэ? (1 оноо)
 A. Тоталитаризм B. Авторитаризм C. Ардчилал D. Либерал ардчилсан E. Ардчилсан бус
45. Шведэд ажилчдын 65 хувь нь ҮЭ-д нэгддэг, Норвегид ажилчид улс төрийн байгууллагад нэгдсэн байдал нь АНУ-ынхаас 2 дахин их байдаг гэсэн мэдээ аль өгөгдөлд тохирох вэ? (1 оноо)
 A. Сайн дурын байгууллага B. Олон нийтийн байгууллага C. Төрийн бус байгууллага
 D. Сонирхлын бүлэг E. Эвлэл, холбоод
46. Доорх өгөгдлүүдээс аль нь сонгуулийн мажоритар системийн онцлогийг илэрхийлж байна вэ? (1 оноо)
 A. Сонгогдож чадаагүй нэр дэвшигчдийн төлөө саналаа өгсөн иргэд төлөөлөлгүй хоцорно
 B. Төлөөллийн шударга ёс алдагддагийг гэтлэх замаар 1889 онд Бельги улсад анх хэрэглэсэн
 C. Парламентын суудлыг улс төрийн намуудад сонгуульд авсан саналтай нь хувь тэнцүүлэн хуваарилна
 D. Санал “үл гээгдэх” зарчим үйлчилнэ
 E. Олон намын тогтолцоо төлөвшихөд нөлөөлнө
47. Социал төрийн нийтлэг шинжийг тоочихдоо үл хамаарах өгөгдөл оруулсан бол аль нь вэ? (1 оноо)
 A. Үндэсний орлогыг нийгмийн эмзэг давхаргад хуваарилна
 B. Нийгмийн баялагийг хуваарилахад оролцох ёсгүй гэж үздэг.
 C. Иргэдийг амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн бодлого явуулдаг
 D. Хүн бүрийг ажлаар хангах буюу орлогын эх үүсвэр олоход нь илүүтэй анхаардаг
 E. Бүх нийтийн сайн сайхан байдал, нийгмийн шударга ёсыг тогтоох зорилготой
48. “Аливаа эгзэгтэй мөчид оновчтой шийдвэрийг шуурхай гаргах чадвартай, түүний арга барилд авторитар ардчилсан шинж хосолно” гэсэн бодомж нь доорх өгөгдлийн алийг нь тодорхойлж байна вэ? (1 оноо)
 A. Туг баригч хошуучлагч B. Худалдаачин хошуучлагч C. Үйлчлэгч хошуучлагч
 D. Гал унтраагч хошуучлагч E. Хошуучлагч
49. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)
 A. Сонгуулийн эрх 1. Санал хураалт явуулах замаар улс төрийн сонголт хийх
 B. Сонгуулийн идэвхгүй эрх 2. Сонгох, сонгогдох эрхээс үүссэн цогц ойлголт
 C. Сонгуулийн идэвхтэй эрх 3. Төрийн байгууллагад сонгогдох
 D. Сонгууль 4. Сонгох буюу сонгуульд саналаа өгөх
 A. A1 B3 C2 D4 B. A2 B4 C3 D1 C. A3 B4 C2 D1 D. A4 B2 C3 D1 E. A3 B1 C2 D4
50. Буруу өгөгдлийг сонгоно уу. (1 оноо)
 A. Монгол Улсын хууль тогтоох байгууллагын нэр нь УИХ.
 B. Монгол Улсын УИХ хууль батлан гаргах чиг үүрэгтэй
 C. Монгол Улс нь УИХ-ын тухай хуультай
 D. Монгол Улсын УИХ нь Засгийн газраасаа байгуулагддаг
 E. Монгол Улсын УИХ нь байнгын ажиллагаатай парламент мөн
51. Бүх нийтийн, чөлөөтэй, шууд, нууц, тэгш эрх зэрэг нь аль өгөгдөлд хамааралтай вэ? (1 оноо)
 A. Сонгуулийн систем B. Сонгуулийн зарчим C. Төлөөллийн ардчилал
 D. Ардчилсан сонгууль E. Иргэдийн оролцооны хэлбэр
52. Нэн шинэ үеийн олон улсын харилцааг хэдий үеэс эхэлсэн гэж судлаачид үздэг вэ? Зөв өгөгдлийг олно уу. (1 оноо)
 A. Дэлхийн I дайны дараах үеэс B. Дэлхийн II дайны дараах үеэс
 C. XX зууны эхэн үеэс D. 1991 оноос E. Эдгээрээс өөр
53. Олон улсын харилцааны сонгодог хэлбэрүүдийн аль нэгэнд нь багтаж орох давхардсан өгөгдлийг олно уу. (1 оноо)
 A. Олон улсын улс төрийн харилцаа B. Олон улсын эдийн засгийн харилцаа
 C. Олон улсын эдийн засгийн гадаад харилцаа D. Олон улсын соёлын харилцаа
 E. Эдгээрээс өөр
54. Дэлхийн улс орнууд социалист, капиталист гэсэн бие биедэй дайсагнасан 2 лагерьт хуваагдан, үзэл суртал, зэр зэвсгийн талаар сөргөлдөн тэмцэж байсныг түүхэнд юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
 A. Зэвсэглэлээр хөөцөлдөж байсан үе B. Олон улсын харилцааны зөрчилтэй үе
 C. Дайны үе D. Хүйтэн дайны үе E. Эдгээрээс өөр
55. Доорх өгөгдлүүдийг харгалзуулна уу. (4 оноо)

1. Ерөнхий Ассамблей А. НҮБ-ын бичиг хэргийг хариуцдаг
 2. Аюулгүйн зөвлөл В. НҮБ-ын энхийг сахиулах үүрэгтэй гол байгууллага
 3. Олон улсын шүүх С. Дэлхийн энх тайванд холбогдолтой бүхий л асуудлаар хуралддаг
 4. Нарийн бичгийн дарга Д. Янз бүрийн улс хоорондын маргаантай асуудлыг нарын газар шийдвэрлэнэ
 А. 1В 2С 3А 4D В. 1D 2С 3А 4В С. 1С 2D 3А 4В D. 1В 2D 2А 4С E. 1С 2В 3D 4А
56. БНМАУ-ын Засгийн газар НҮБ-ын дүрмийг зөвшөөрч, түүний гишүүн болох хүсэлтээ анх 1946 оны 6-р сард гаргаснаасаа хойш 8 удаа илэрхийлсэн бөгөөд 15 жилийн дараа биелэлээ олжээ. Монгол улс НҮБ-д элссэн хугацааг өгөгдлөөс олно уу. (1 оноо)
 А. 1961.10.25 В. 1961.10.27 С. 1962.10.25 D. 1962.10.27 E. 1960.10.10
57. Монгол улсын гадаад бодлогын тулгуур үндсийг аль нь тодорхойлох вэ? (1 оноо)
 А. Монгол Улсын Ерөнхийлөгч В. Үндсэн хуулийн цэц
 С. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл D. УИХ E. Монгол Улсын Засгийн Газар
58. Европын холбооны нэгдсэн мөнгөн тэмдэгтийг нэрлэнэ үү. (1 оноо)
 А. Доллар В. Марк С. Фунт стерлинг D. Франк E. Евро
59. Монгол Улсын УИХ-ын шийдвэрээр цэрэг, цагдаагийн албан хаагчдыг НҮБ-ын Энхийг сахиулах болон бусад үйл ажиллагаанд оролцуулж байна. Ийм үйл ажиллагаанд холбогдохгүй улс, тивийг өгөгдлөөс олно уу. (1 оноо)
 А. Африк тив В. Сьерра Леон С. Афганистан D. Ирак E. БНСУ
60. Буруу холбоосыг олно уу. (1 оноо)
 А. НҮБ - 1945 онд АНУ-ын Сан Франциско хотод байгуулсан
 В. ЮНИСЕФ - 1946 онд байгуулагдсан
 С. UNFPA - НҮБ-ын Хүн амын сан
 D. Европын холбоо - НҮБ-ын төрөлжсөн байгууллага
 E. АНУ - “Мянганы сорилын сан” хөтөлбөр

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: 1. Энэ хэсэгт өгөгдсөн бодлогыг бодно Зөв бодсон бодлого бүр 5 оноотой.

Бодлого №1 : “В” улсын нийт хүн амын тоо 2 сая, хүн амын 40% нь ажиллагсад бөгөөд зөвхөн 10500 хүн ажил идэвхтэй хайж байгаа бол ажилгүйдлийн түвшинг тооц.

Бодлого №2: Нэгэн барааны эрэлтийн функц $Q_D=200-5P$, нийлүүлэлтийн функц нь $Q_S=50+15P$ гэж өгөгдсөн бол зах зээлийн тэнцвэрт үнийг ол.

- a. 7,5 b. 12,5 c. 15 d. 25

Бодлого №3 Монгол улсад тухайн жилийн насанд хүрэгчдийн сургуульд суралцсан дундаж хугацаа 89.7, сургуульд суралцах хугацаа 80.3 гэж үзье. Эндээс сургуульд суралцах хугацааны индексийг ол

Бодлого №4 Монгол улсын тухайн жилийн хүн амын дундаж наслалт 70.1 байсан гэж үзвэл дундаж наслалтын индексийг ол

